



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 26 өдөр

Дугаар Д/313

Хэрлэн сум

Онцгой байдлын газарт
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтууд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны Аравдугаар хуралдааны “Гучин сая мод” хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай 07 дугаар тогтоол, 2023 оны Арван наймдугаар хуралдааны “Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 02 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх хүрээнд Чингис хотын төвөөс Хүндэтгэлийн хаалга хүртэл төв замын дагуу шинээр ойн зурвас байгуулах, хамгаалалтын хашаа барих, модны нүх ухах ажилд зориулж, Хэнтий аймгийн Онцгой байдлын газарт 18,750,000 (арван найман сая долоон зуун тавин мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх хөрөнгийг 2023 оны аймгийн төсөвт тусгагдсаны дагуу Засаг дарга дансны төвлөрсөн арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
05 дугаар сарын 05-ны өдрийн
05/05 дугаар захирамжийн хавсралт

Хөрөнгө зарцуулалтын тооцоо

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ ₮	Нийт үнэ ₮	Тайлбар
1	Багаж тоног төхөөрөмж	ш	2	575,000	1,150,000	Нүх ухагч мотор
2	Модны нүх ухах механизмын зардал	ш/өдөр	10	800,000	8,000,000	Бага оврын шанагатай трактор өдөрт 300 ш нүх ухахаар тооцов.
3	Ажиллах хүчний хоолны зардал, хамгаалах хэрэгсэл, хөдөлмөр	Хүний тоо	150	14,000	2,100,000	10 хүний бүрэлдэхүүнтэй баг 15 хоног ажиллахаар тооцов.
4	Хар шороо, бууц тээвэр	М.куб	180	20,000	3,600,000	1 хово машинд 18м3 шороо/бууц ачиж буулгахаар тооцов.
5	Усалгааны зардал	тонн	20	195,000	3,900,000	Мод тарих үеийн усалгаа 20 тн усны машинаар 30 удаа зөөх (шатахуун болон усны насосын түлшний зарцуулалтаар тооцов)
	Нийт дүн				18,750,000	